



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/221

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаан-Уул сумын иргэн (Бөөрний архаг дутмагшил оноштой) Б.Чимгээгийн эмчилгээний зардалд 500,000 (Таван зуун мянган) төгрөг, Турк улсад эмчлэгдэхэд санхүүгийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын харьяат (Тархины саажилт, булчингийн чангарал оноштой) Цэдэнбалын Золбоод 2,000.000 (Хоёр сая) төгрөг, эмчилгээний зардал хүссэн Мөрөн сумын 3-р хорооны иргэн (Ходоодны хорт хавдар оноштой) Ц.Дашдаваад 1,000.000 (Нэг сая) төгрөг, Монгол Улсын Хүний гавьяат эмч нарын нэрэмжит “Энэ жилдээ-Эрүүл жиндээ” арга хэмжээний зардалд 1,200.000 (Нэг сая хоёр зуун мянган зуун) төгрөг, Үндэсний бөхийн аварга шалгаруулах барилдааны арга хэмжээнд 2,200,000 (Хоёр сая хоёр зуун мянган зуун мянган) төгрөг, Жаргалант сумын харьяат Б.Амар “Манам” хотод зохион байгуулагдах “Аварга” шалгаруулах волейболын тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг 2,000.000 (Хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 9,100.000 (Есөн сая нэг зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6717010041